



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/103

Амардалай

Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 279 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2023 оны А/459 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хөдөө аж ахуйн салбар болон төв суурин газрын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах зарим арга хэмжээний тухай" Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 27 ны өдрийн 02 тоот албан даалгавар, 2023-2024 оны Аймгийн Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын явцад хяналт тавих, хэрэгжилтийг тооцох үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал (Засаг даргын орлогч)

Гишүүд: Д.Наранцэцэг (МЭТ-ийн дарга)

Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)

Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

А.Адъяа (Ган-Илч ХХК Дэлгэрцогт салбарын дарга)

Ц.Шаравдагва (Ш/Үйлчилгээний засварын техникч)

Г.Дэжидсүрэн (Сангууд хариуцсан нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: Б.Баттогтох (ХААТ-ийн мэргэжилтэн)

2. "Хөдөө аж ахуйн салбар болон төв суурин газрын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж, батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны 10 дугаар сарын 15 ны өдрийн дотор Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэхийг ажлын хэсэг (Л.Золжаргал), (Б.Баттогтох) нарт үүрэг болгосугай.

3. Засгийн газрын тогтоол, аймаг, сумын Засаг даргын албан даалгаврын хэрэгжилтийг 2023 оны 10 дугаар сарын 15 ны өдрийн дотор зохион байгуулж, дүн мэдээг 10 дугаар сарын 20 ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (Л.Золжаргал) д даалгасугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ